

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖЛЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВӨӨС ЭРГЭН
ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ КОНЦЕССЫН “БАРИХ-
ШИЛЖҮҮЛЭХ” ТӨРЛӨӨР ХЭРЭГЖСЭН “БАЯНХОНГОР
АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМАНД 100 ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ӨРГӨТГӨЛ БАРИХ ТӨСӨЛ”-ИЙН
ХЭРЭГЖИЛТ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

**Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл**

Утас: 263755, цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитын менежер Б.Саруул

Утас: 261805, цахим хаяг: saruulb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Болормаа

Утас: 261456, цахим хаяг: bolormaab@audit.gov.mn

Аудитор М.Доржмаа

Утас: 261456, цахим хаяг: dorjmaam@audit.gov.mn

Аудитор Ш.Наранбаатар

Утас: 261456, цахим хаяг: naranbaatarsh@audit.gov.mn

Улаанбаатар хот
2020 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/72

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/70 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн “Баянхонгор аймгийн Өлзийт суманд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл”-ийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Үндэсний хөгжлийн газар /Б.Баярсайхан/-т тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар /С.Оюунгэрэл/-т, аудитын тайлан, ажлын баримтыг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Б.Болормаа/-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....	4
Нэг. Төслийн танилцуулга	4
Хоёр. Аудитын дүн.....	5
Дүгнэлт.....	12
Зөвлөмж.....	13
Хавсралт 1: Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын стандарт
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1.7 дахь хэсэгт “Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гарах хүртэлх хугацаанд санхүүжилтийг түр хойшлуулах” гэж заасныг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/100 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1¹, 6.3.3² дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дүгнэлт гаргах ажлыг хийлээ.

Аудитын зорилт:

“Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад ажлын зорилт чиглэгдэв.

Аудитыг дараах чиглэлээр төлөвлөж, хэрэгжүүлэв. Үүнд:

- Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад хууль, эрх зүйн шаардлагыг хангасан төслийг тусгаж, концесс эзэмшигчийг хуулийн дагуу сонгон шалгаруулсан эсэх;
- Концессын төслийн гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх гэсэн дэд зорилтуудын хүрээнд гүйцэтгэлээ.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл, хамарсан хүрээ:

Дүгнэлт гаргах ажилд Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт (300), Төрийн аудитын стандарт MNS6817:2020, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, Барилгын хөгжлийн төв, “Жишиг бетон” ХХК, зураг төсвийг зохиогч, магадлал хийсэн хуулийн этгээд, концесс эзэмшигч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг хамруулан, дээрх байгууллагуудаас төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой баримтуудыг гаргуулан авч, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах горимыг ашиглан нотлох зүйл цуглуулж, баримтжуулан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Үндэсний хөгжлийн газраас концесс эзэмшигч “Жишиг бетон” ХХК-тай 2016 онд байгуулсан “Баянхонгор аймгийн Өлзийт суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл”-ийн гэрээний хэрэгжилтэд хийсэн аудитад хөндлөнгийн мэргэжлийн байгууллагыг шинжээчээр оролцуулж, концессын зүйлийн зураг төслийн боловсруулалт, баталгаажуулалт, зөвлөхийн хяналт, барилга угсралтын ажлын гүйцэтгэлд мэргэжлийн дүгнэлт гаргуулав.

¹ шалгаагдагч этгээдэд ... санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

² төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх;

Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Концессын тухай хууль;
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг;
- Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам"; 2 дугаар хавсралтаар баталсан "Концесс олгох уралдаант шалгаруулалтын санал үнэлэх журам";
- Төрийн өмчийн хороо (хуучин нэрээр)-ны 2010 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Концессын зүйлийн зардал, ашгийн тооцоо хийх түр аргачлал";
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам";
- Засгийн газар болон "Жишиг бетон" ХХК-ийн хооронд 2016 онд байгуулсан "Баянхонгор аймгийн Өлзийт суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл"-ийн "барих-шилжүүлэх" концессын гэрээ;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Б.Саруул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Болормаа, аудитор М.Доржмаа, Ш.Наранбаатар нар гүйцэтгэлээ.

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. УИХ-ын 2015 оны "Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 108 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317, Засгийн газрын 2016 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 73, 2016 оны "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 308 дугаар тогтоолуудын дагуу "Баянхонгор аймаг, Өлзийт суманд цэцэрлэгийн барилга барих төсөл"-ийн концессын гэрээг "Жишиг бетон" ХХК-тай байгуулах эрхийг Хөрөнгө оруулалтын газар /хуучин нэрээр/-т олгожээ.

Хүснэгт 1. Төслийн товч мэдээлэл

Концессын зүйлийн нэр	Баянхонгор аймгийн Өлзийт суманд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл
Концессын төрөл	Барих-шилжүүлэх
Концесс эзэмшигч	"Жишиг бетон" ХХК
Гэрээний үнэ буюу төслийн нийт хөрөнгө оруулалт	1,159,677,684.00 төгрөг
Хэрэгжүүлэх хугацаа	2016.06.20 – 2016.11.01

Эх сурвалж: Концессын гэрээ

1.2. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх "барих-шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалт"-д төслийн төсөвт өртгийг 1.159.7 сая төгрөгөөр тооцож, хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг 2020 онд бүрэн санхүүжүүлэхээр тусгасан байна.

ХОЁР. АУДИТЫН ДҮН

Хуулийн шаардлага хангасан төслийг Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгасан байна

2.1 УИХ-ын 2015 оны “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 108 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтаас хасагдсан нэр бүхий төсөл, арга хэмжээнээс нэг маягийн зураг төслөөр барьж болох, 320 хүртэлх суудалтай сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгыг 2016 оны 1 дүгээр улиралд багтаан концессоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төсөвт тусгахаар шийдвэрлэсний дагуу Баянхонгор аймгийн 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих ажлыг хэрэгжүүлэхээр болжээ.

2.2 Баянхонгор аймгийн Өлзийт сумын хүүхдийн цэцэрлэгийн барилга 1976 онд 50 хүүхдийн хүчин чадалтайгаар ашиглалтад орсон бөгөөд цэцэрлэгийн барилга цэвэр усан хангамж, ариутгах татуургад холбогдоогүй, хэд хэдэн удаа үерийн усанд автсан, хаяавч хэсгүүд эвдэрч, ханын шавардлага хуурч хөндийрсөн, өвөлдөө цонх, хаалга цан цохидог байдлаас шалтгаалан ангиудад мөөгөнцөр үүссэн, дээврийн хавтан хагарч цуурсан зэргээр сургалтын үйл ажиллагаа явуулах стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй болсон байна.

2.3 Ийнхүү сургуулийн өмнөх насны хүүхдүүд тухтай, аюулгүй орчинд сурч хүмүүжих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Баянхонгор аймгийн Өлзийт суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга барихаар төлөвлөжээ.

2.4 Концессын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3³ дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 7 дахь хэсэгт “Баянхонгор, 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих төсөл”-ийг тусгасан байна.

Хүснэгт 2. Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгасан төслийн мэдээлэл

Концессын зүйлийн нэр	Концессын зүйлийн тодорхойлолт	Концессын төрөл	Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ	Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх эсэх	Уралдаант шалгаруулалт явуулах эсэх
Баянхонгор, 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих төсөл	Баянхонгор, 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих	Барих-шилжүүлэх	Баянхонгор, 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих, шилжүүлэх	Улсын төсөв	Уралдаант шалгаруулалт явуулах

Эх сурвалж: Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралт

2.5 Засгийн газрын 2013 оны “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай” 317 дугаар тогтоолоор дээрх төслийн концесс эзэмшигчийг уралдаант шалгаруулалт явуулж сонгохоор баталжээ.

Уралдаант шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулсан байна

2.6 Засгийн газрын 2016 оны 73 дугаар тогтоолоор “Баянхонгор аймгийн 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих” багц төсөл хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд сонгон шалгаруулалтаар нийт төсөлд оролцох гүйцэтгэгчийн санал ирээгүй, цэцэрлэг тус бүрээр оролцох саналууд ирсэн тул уралдаант шалгаруулалт хүчингүй болсон байна.

³ 10.3-т Концессын зүйлийн жагсаалтад дараах зүйлийг тусгана:

10.3.1-д концессын зүйлийн нэр, тодорхойлолт, концессын төрөл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ;

10.3.2-т төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх;

10.3.3-д энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан уралдаант шалгаруулалт явуулах, эсхүл шууд гэрээ байгуулах эсэх.

2.7 Концессын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3⁴-т заасны дагуу Хөрөнгө оруулалтын газрын /хуучин нэрээр/ даргын 2016 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/53 дугаар тушаалаар “Баянхонгор аймаг Өлзийт суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих төсөл”-ийн ажлыг гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгох, концесс олгох, хэлэлцээ хийх, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, “Жишиг бетон” ХХК-д шууд гэрээ байгуулах хэлэлцээр хийх урилгыг хүргүүлсэн байна.

2.8 Засгийн газрын 2016 оны “Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай” 308 дугаар тогтоолын дагуу “Жишиг бетон” ХХК-тай концессын гэрээ байгуулах эрхийг Хөрөнгө оруулалтын газарт /хуучин нэрээр/ олгож, гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулахыг Аж үйлдвэрийн сайд /хуучин нэрээр/-д зөвшөөрсөн байна.

2.9 Дээрх тогтоолын дагуу Засгийн газрыг төлөөлж 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Хөрөнгө оруулалтын газар /хуучин нэрээр/ болон “Жишиг бетон” ХХК-ийн хооронд 1,159.7 сая төгрөгийн үнийн дүнтэй “барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээ байгуулагдсан байна.

Хүснэгт 3. Концессын зүйлийн эргэн төлөлтийн хуваарь

Гэрээний үнийн дүнд эзлэх хувь	Мөнгөн дүн /төгрөгөөр/	Төлбөр гүйцэтгэх хугацаа
60 хувь	695,806,610.00	2017 оны 2 дугаар улирал
40 хувь	463,871,074.00	2017 оны 4 дүгээр улирал

Эх сурвалж: Концессын гэрээ

2.10 Ийнхүү төслийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн хуваарийг концессын гэрээнд дээрх байдлаар тусгасан байна.

Концессын гэрээг баталгаажуулахад хугацаа алдсан байна

2.11 Концессын гэрээ хүчин төгөлдөр болох шаардлагыг хэрхэн хангасныг авч үзвэл,

Хүснэгт 4. Концессын гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлийг хангасан байдал

Концессын гэрээнд заасан гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлүүд	Хэрэгжүүл сэн эсэх	Шаардлагыг заасан хугацаанд хангасан эсэх
1.12.1. Эрх бүхий этгээдийн үүрэг		
1.12.1.а. Барилгын ажлын захиалагчийн хяналтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэрээг ... байгуулах	тийм	Үндэсний хөгжлийн газраас 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр 36/1 дугаартай төслийн захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээг Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан байна
1.12.1.б. Концесс эзэмшигч нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тохиолдолд холбогдох тусгай зөвшөөрлүүдийг саадгүй олгох	тийм	Хангасан
1.12.2. Концесс эзэмшигчийн үүрэг		
1.12.2.а. Ажил гүйцэтгэх хуваарийг ... батлуулсан байх	тийм	-Ажил гүйцэтгэх хуваарийг Үндэсний хөгжлийн газраар батлуулсан байна
1.12.2.б. Төслийн нийт хөрөнгө оруулалтын 4/1-ээс доошгүй хувьтай тэнцэх 289.9 сая төгрөгийг ...арилжааны банкин дахь өөрийн дансанд байршуулж, төслийн зориулалтын дагуу зарцуулах.	тийм	-Төслийн нийт хөрөнгө оруулалтын 4/1-ээс доошгүй хувьтай тэнцэх 289.9 сая төгрөгийг Голомт болон ХААН банкин дахь “Жишиг бетон” ХХК-ийн дансанд байршуулж, зориулалтын дагуу төслийн үйл ажиллагаанд зарцуулжээ
1.12.2.в. Барилга, угсралтын ажлын даатгалын гэрээ;	үгүй	-Барилга, угсралтын ажлын даатгалын гэрээ байгуулсан гэх нотлох баримтыг ирүүлээгүй;
1.12.2.г. Амь нас гэнэтийн ослын даатгалын гэрээ;	тийм	-Амь нас гэнэтийн ослын даатгалын гэрээг байгуулсан байна
1.12.2.д. Хариуцлагын даатгалын гэрээ	тийм	-Хариуцлагын даатгалын гэрээ байгуулсан

⁴ Концессын тухай хуулийн 17.1.3.уралдаант шалгаруулалт зарласан боловч санал ирээгүй, эсхүл шаардлагад нийцсэн санал ирээгүй бөгөөд уралдаант шалгаруулалт дахин зарласан ч шаардлагатай хугацаанд санал ирэх магадлал бага гэж эрх бүхий этгээд үзсэн

1.12.2.е. Төслийн санхүүжилтийн гэрээ	үгүй	-Төслийн санхүүжилтийн гэрээ байгуулаагүй, зөвхөн төслийн хөрөнгийн эх үүсвэрийг Төрийн банк, ББСБ, хувь хүнээс авсан зээлийн гэрээтэй холбоотой баримтыг ирүүлсэн
1.13. Гэрээний 1.12-т заасан нөхцөл хангагдсан эсэх талаар Эрх бүхий этгээд дүгнэлт гаргана.	тийм	-Үндэсний хөгжлийн газрын 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдөр гэрээний 1.12-т заасан нөхцөлүүд хангагдсан гэсэн дүгнэлт гаргажээ
1.17 Энэхүү гэрээний 1.12.1 болон 1.12.2-т заасан ... нөхцөлүүд бүрэн хангагдсаныг эрх бүхий этгээд дүгнэж Гэрээ хүчин төгөлдөр болсныг ... Концесс эзэмшигчид албан тоотор мэдэгдсэн тохиолдолд төслийн саналын баталгааг цуцална.	тийм	-Гэрээний 1.12.1 болон 1.12.2-т заасан нөхцөлүүд бүрэн хангагдсаныг Үндэсний хөгжлийн газраас дүгнэж, Гэрээ хүчин төгөлдөр болсныг “Жишиг бетон” ХХК-д албан бичгээр мэдэгдсэн байна.

Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар

2.12 Концессын гэрээний 1 дүгээр зүйлийн 1.12-т “Энэхүү гэрээнд гарын үсэг зурсан өдрөөр гэрээ байгуулагдсанд тооцогдох бөгөөд тухайн өдрөөс хойш 2 сарын дотор дор дурдсан нөхцөл бүрэн хангагдсанаар гэрээ хүчин төгөлдөр болно” гэж заасан боловч Хөрөнгө оруулалтын газар 2016 онд татан буугдсантай холбоотойгоор Үндэсний хөгжлийн газар концессын гэрээний хүчин төгөлдөр болох нөхцөл хангасан тухай дүгнэлтийг 2017 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталгаажуулсан байна.

2.13 Үндэсний хөгжлийн газраас концессын гэрээнд гарын үсэг зурснаас 15 сарын дараа 2017 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 01/852 дугаартай албан бичгээр “Баянхонгор аймгийн Өлзийт суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл”-ийн гэрээ хүчин төгөлдөр болсон талаар “Жишиг бетон” ХХК-д мэдэгджээ.

Барилгын зураг төсөл нь холбогдох хууль, тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан байна

2.14 Барилгын инженер геологийн судалгааг 2015 онд “Барнаб” ХХК гүйцэтгэж, инженер геологийн дүгнэлтээр “барилгын суурь суусан буурь хөрс нь элсэнцрээр чигжигдсэн хайрган хөрс байна” гэж тодорхойлсон байна.

2.15 Барилгын зураг төслийг “Хангайн нар” ХХК-ийн инженер Д.Өлзийсайхан, Ц.Мөнхбаяр, О.Мөнхбаатар нар боловсруулж, барилгын бүтээцийн зурагт 2016 онд зөвлөх инженер Ц.Бат-Очир экспертийн дүгнэлт гаргаж, баталгаажуулсан бөгөөд барилгын холболтын зургийг “Хангайн нар” ХХК 2016 онд боловсруулж, холбогдох байгууллага хянан баталгаажуулсан байна.

2.16 Цэцэрлэгийн барилгын гадна холбооны ажлын зургийг 2016 онд “Хангайн нар” ХХК-д ХН-01/2016 шифртэйгээр, инженер О.Эрдэнэчулуун “МХС” ТӨК-ийн 2015 оны №С6/2015 дугаартай техникийн нөхцөлийг үндэслэн боловсруулсан байна.

2.17 Техникийн нөхцөлийн дагуу шинээр 2 ширхэг багана босгон цэцэрлэгийн дээвэр дээр кабелийн зогсуур хийж, агаарын 10 хос кабель барилга руу оруулахаар төлөвлөсөн байна. Уг ажлын зурагт 2016 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Барилгын хөгжлийн төвийн улсын эксперт Ж.Өлзийбаяр магадлал хийж, дүгнэлт гаргажээ.

2.18 Барилгын зураг төслийн архитектур төлөвлөлт болон бүтээцийн шийдэл нь барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөж буй норм дүрэм, стандарт, инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу төлөвлөгдсөн, сургуулийн өмнөх насны хүүхдийн сурч, хүмүүжих таатай орчны шаардлагад нийцсэн байна.

2.19 Барилгын гадна, дотор халаалт, агаар сэлгэлт, ус хангамж, ариутгах татуургын инженерийн шугам сүлжээний зураг төсөл нь норм дүрэм, стандартын шаардлагыг хангасан байна.

Төсөвт өртгийг холбогдох журмын дагуу боловсруулсан байна

2.20 Баянхонгор аймгийн Өлзийт суманд баригдсан 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг нэг маягийн зураг, төсвөөр барихаар тендерт гүйцэтгэгчээр "Жишиг бетон" ХХК шалгарсан байна. Үүнд:

- Цэцэрлэгийн барилгын төсвийг 2016 онд мэргэжсэн төсөвчин Ц.Гэндэн гүйцэтгэж Барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлтээр нийт 1,360.9 сая төгрөгөөр;
- Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын даргын 2015 оны 24/2015 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэн Баянхонгор аймгийн Өлзийт сумын Засаг дарга болон "Хангайн нар" ХХК-ийн хооронд 2015 оны 11/2015 дугаартай зураг төсөл боловсруулах гэрээ байгуулсан байна. Барилгын хөгжлийн төвийн 2016 оны 450/2016 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр барилгын холболтын ажлын зураг төслийг тус тус баталгаажуулсан байна.

2.21 Барилга байгууламжийн үе шатны ажлын гүйцэтгэлийг 2019 оны 8 дугаар сарын 09-ний өдөр Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан, Барилгын хөгжлийн төвийн дарга Ц.Амарсанаа, захиалагч Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын дарга Э.Мөнхсүх нар тус тус баталгаажуулсан байна.

Төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг гэрээнд заасны дагуу бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна

2.22 Концессын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт "барих-шилжүүлэх" концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан..." гэж заасны дагуу концесс эзэмшигч төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг Төрийн банк болон банк бус санхүүгийн байгууллага, хувь хүнээс авсан зээл болон компанийн хөрөнгөөр бүрдүүлжээ. Үүнд:

Хүснэгт 5. Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлэлт

№	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Зээлийн гэрээ			Зээлийн хүү /сард/	/төгрөгөөр/ Зээлийн хүүгийн төлбөр
		дүн	байгуулсан огноо	дуусгавар болох огноо		
1	Төрийн банк	30,000,000.00	2017.11.10	2018.11.10	2.5%	6,014,502.00
2	"Дөргөн эх" ББСБ	27,000,000.00	2018.11.10	2019.04.25	5%	7,505,000.00
3	"Хустын ургац" ББСБ	60,000,000.00	2018.03.09	2018.09.05	4%	13,374,247.00
4	Иргэн Б.Энхцэцэг	17,000,000.00	2018.09.07	2018.11.07	6%	2,040,000.00
5	Иргэн Ч.Ганбатаас	80,000,000.00	2017.08.03	2018.08.03	3%	26,388,384.00
6	Иргэн С.Сэргэлэнгээс	43,000,000.00	2018.12.10	2019.06.10	4%	10,320,000.00
7	Бусад эх үүсвэр	837,035,551.00				
	ДҮН	1,094,035,551.00				65,642,133.00

Эх сурвалж: Концесс эзэмшигчийн санхүүгийн баримт

2.23 Концессын гэрээний 1 дүгээр зүйлийн 1.8-д "Төслийн барилга угсралт болон шаардлагатай бусад зардлын санхүүжилтийг ... Монгол Улсын аль нэг арилжааны банк дахь концесс эзэмшигчийн дансанд байршуулж төслийн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасны дагуу гүйцэтгэгч өөрийн болон өөрийн боломжоор олж бүрдүүлсэн хөрөнгийг Голомт болон ХААН банк дахь зөвхөн тухайн төсөлд зориулж нээсэн дансаар дамжуулан зарцуулж тайлагнасан байна.

Барилга угсралтын ажлууд зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийгджээ

2.24 Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1-д “барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих”, мөн хуулийн 40.1.17-д “барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах” гэсэн заалтын хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараах байдалтай байна.

2.25 Баянхонгор аймгийн Өлзийт суманд баригдсан 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын магадлалгүй ажлын төсвийг 2019 онд тэргүүлэх төсөвчин Ц.Гэндэн 19.8 сая төгрөгөөр тооцсон боловч Барилгын хөгжлийн төвөөс 2019 оны 08 дугаар сарын 09-ний өдөр гүйцэтгэгчийн магадлалгүй ажилд тооцсон 19.2 сая төгрөгийг нийт гүйцэтгэлээс хасаж хянан баталгаажуулсан байна.

2.26 Тус цэцэрлэгийн барилгын гадна цахилгаан хангамжийг Баянхонгор аймгийн “Цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн 2015 оны 2015/029 дугаартай техникийн нөхцөл, “Цахилгаан байгууламжийн дүрэм”-ийн дагуу төлөвлөн гүйцэтгэсэн байна.

2.27 Аудитын дүгнэлт гаргах ажилд мэргэжлийн шинжээчээр ажилласан баг төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцаад дараах дүгнэлтийг хийсэн байна. Үүнд:

- *Барилга нь 30.3 х 24.7 м /748.4 м.кв/ хэмжээтэй, “Г” хэлбэртэй нэг блокоос бүтсэн, зоорьтой, 2 давхар, даацын тоосгон ханатай барилга, 9 өрөө бүхий барилга барилга баригдсан;*
- *Батлагдсан гүйцэтгэлийн материалын зардлын нэгжийн үнийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих барилга байгууламжид ашиглагддаг “Барилгын материал, бүтээц эдлэлийн үнийн лавлах, түүнийг хэрэглэх заавар”-ыг үндэслэн харьцуулалт хийхэд зөрүү гараагүй;*
- *Гүйцэтгэгч ААН цэцэрлэгийн гадна явган замыг өнгөт хавтангаар хийхээр зураг тусгасныг цутгаж хийсэн, мөн дээврийг ЕРОХУ будгаар будахаар хуйлмал дээвэр хийсэн, гал тогооны өрөөнд тос баригч төхөөрөмжийг суурилуулаагүй зэрэг ажлууд нийт гүйцэтгэлийн дүнгээс 13.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна.*
- *“Жишиг бетон” ХХК барилга угсралтын ажлын төсвийг тооцохдоо зарим нэр төрлийн материалын үнийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих барилга байгууламжид ашиглагддаг Барилгын материал, бүтээц эдлэлийн үнийн лавлахын үнээс бага үнээр тусгасан байна.*

2.28 Төслийн ажлыг газар дээр нь шалган, хийсэн ажлын гүйцэтгэлийн тооцооллыг тулган баталгаажуулахад Үндэсний хөгжлийн газар болон Барилгын хөгжлийн төвөөс уг төслийн ажлын гүйцэтгэлийг 1,140.5 сая төгрөгөөр хянан баталгаажуулсан боловч аудитаар 1,156.1 сая төгрөгийн бодит гүйцэтгэл гарч байна.

2.29 Энэ нь “Жишиг бетон” ХХК нь 29.4 сая төгрөгийн нэмэлт ажлыг барилга байгууламжийн захиалагч, ашиглагч байгууллагын саналын дагуу хийж гүйцэтгэсэнтэй холбоотой бөгөөд уг нэмэлт ажлын төсвийг тэргүүлэх төсөвчин Ц.Гэндэн хянаж баталгаажуулсан байна.

Хүснэгт 6. Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/					
Магадлалаар баталгаажсан ажлын төсөв	ҮХГ, БХТ-ийн хянасан гүйцэтгэл	Ашиглагч, захиалагчийн хүсэлтээр хийсэн ажлын дүн	Гүйцэтгээгүй ажлын дүн	Бодит гүйцэтгэлийн дүн	Зөрүү
1	2	3	4	5=2+3-4	6=1-5
1,159.7	1,140.5	29.4	13.8	1,156.1	3.6

2.30 Гүйцэтгэгч зарим дутуу гүйцэтгэсэн ажлыг аудитын хугацаанд бүрэн хийж дуусгасан байна. /бохирын резин солих, цахилгааны гэрэлтүүлэг, гадна дулааны худгийн таг, ангиудын хагарсан цонхны шилийг солих, гадна борооны усны хаялгын чиглэлийг өөрчлөх, дээвэрт чулуугүй хар цаас нэмж наах зэрэг/

2.31 Концесс эзэмшигч дутуу хийсэн ажлаа бүрэн хийсэн тухай тайлан болон фото зургаар баримтжуулсан гүйцэтгэлийг төслийн ашиглагч байгууллагаас Үндэсний аудитын газарт 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 26 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Эрх бүхий байгууллагаас төслийн хэрэгжилтийг дүгнэж, үнэлгээ өгөөгүй байна

2.32 "Хангайн нар" ХХК нь барилгын үе шатны ажлуудад зохиогчийн хяналт хийж ил далд ажлын актуудыг баталгаажуулсан бөгөөд "Жишиг бетон" ХХК-ийг барилга угсралтын ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгэсэн гэж дүгнэсэн байна.

2.33 Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19-т "барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах" гэж заасны дагуу цэцэрлэгийн барилгын угсралтын үе шатны ажлуудад аймгийн ГХБХБГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, тайлан гаргаж, илд далд ажлын акт үйлдэн, фото зургаар баталгаажуулсан байна.

2.34 Үндэсний хөгжлийн газар болон Барилгын хөгжлийн төвийн хооронд 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр 36/1 дугаартай 19.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Баянхонгор аймаг Өлзийт суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих төсөл"-ийн барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээг байгуулсан байна.

2.35 Дээрх гэрээний 3 дугаар зүйлийн 3.2-т "Барилгын ажлын захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч нь барилгын ажлын захиалагчид барилгын ажлын явцын тайланг гарган өгөх" гэснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, Барилгын хөгжлийн төв төслийн үе шатны ажлын явц, гүйцэтгэлд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн тухай ажлын тайланг баталгаажуулж Үндэсний хөгжлийн газарт ирүүлээгүй байна.

2.36 Үндэсний хөгжлийн газар нь дээрх гэрээний 2 дугаар зүйлийн 2.2.4-т "барилгын ажлын захиалагчийн хяналтын тайланг барилгын ажлын үе шат бүрд гаргуулах" гэж заасныг Барилгын хөгжлийн төв бүрэн биелүүлээгүй байхад 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гэрээт ажлын төлбөрийг бүрэн шилжүүлсэн байна.

2.37 Ийнхүү Үндэсний хөгжлийн газар Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8-д "Концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх" гэж заасны дагуу гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллаагүй байна.

Төслийг хэрэгжүүлснээр сургуулийн өмнөх насны хүүхдүүд аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөл бүрдсэн байна

2.38 Төслийн ажил дууссан тухай гүйцэтгэгчээс ирүүлсэн мэдэгдлийн дагуу Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллан 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01 дугаартай дүгнэлтээр "Баянхонгор аймаг, Өлзийт сум, 6 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдсан 100 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламжийн ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагын хангасан" гэж үзээд барилгыг ашиглалтад оруулсан байна.



2.39 Баянхонгор аймгийн Өлзийт суманд шинээр баригдсан хүүхдийн цэцэрлэгийн ашиглалтын талаар тус цэцэрлэгийн захиргаанаас Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн 19 дугаартай албан бичигт "Цэцэрлэгийн барилга баригдсанаар Өлзийт сумын сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд сурч боловсрох таатай орчин бүрдсэн бөгөөд одоогоор 17 багш, 122 суралцагчтай үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна" гэж дурджээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Концессын гэрээний хүчин төгөлдөр болох нөхцөл хангасан тухай дүгнэлтийг хугацаа алдаж баталгаажуулсан байна.
- "Баянхонгор аймгийн Өлзийт суманд баригдсан 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл"-ийн төсөвт өртөг нь батлагдсан зураг төслийн дагуу зохиогдож, хянагдсан байна.
- Төслийн зураг төсөл барилгын салбарт мөрдөгдөж байгаа норм, дүрэм, зургийн даалгавар, техникийн нөхцөлийн шаардлагыг хангасан бөгөөд эрх бүхий байгууллагаар хянагдаж магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан байна.

ЗӨВЛӨМЖ

Дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Монгол Улсын Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт:

- Төслийн санхүүжилтийн эргэн төлөлтийг концессын гэрээнд заасан хуваарийн дагуу олгох арга хэмжээ авах.

Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд:

- Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8-д “Концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих, концессын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх”, мөн концессын гэрээний хэрэгжилтийг бүрэн ханган ажиллах.

Хавсралт 1

Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл

/төгрөгөөр/

Зардлын нэр	Магадлалаар баталгаажсан ажлын төсөв	ҮХГ, БХТ-өөс хянасан гүйцэтгэл	Ашиглагч, захиалгийн хүсэлтээр гүйцэтгэсэн ажлын дүн	Гүйцэтгээгүй ажлын дүн	Бодит гүйцэтгэлийн дүн
А	1	2	3	4	5=2+3-4
Цалин	221,160,643.0	221,160,643.0		1,964,463.0	219,196,180.0
Материал	441,842,497.0	441,842,497.0	29,379,804.0	8,415,905.0	462,806,396.0
Тээвэр	32,884,516.0	32,884,516.0		750,596.0	32,133,920.0
Машин ашиглалт	53,113,773.0	53,113,773.0		70,490.0	53,043,283.0
Шууд зардлын дүн	749,001,429.0	749,001,429.0	29,379,804.0	11,201,454.0	767,179,779.0
Нэмэгдэл зардал	84,187,775.0	84,187,775.0		725,631.0	83,462,144.0
Ашиг	124,978,381.0	124,978,381.0		1,563,849.0	123,414,532.0
Барилга угсралт ажлын дүн	958,167,585.0	958,167,585.0	29,379,804.0	13,490,934.0	974,056,455.0
НӨАТ	95,816,759.0	95,816,759.0			95,816,759.0
Нормчлолын сан	1,724,701.0	1,724,701.0	52,884.0		1,777,585.0
Дүн	1,055,709,045.0	1,055,709,045.0	29,432,688.0	13,490,934.0	1,071,650,799.0
Захиалагчийн албаны зардал	19,163,352.0	19,163,352.0		318,578.0	18,844,774.0
Дүн	1,074,872,397.0	1,074,872,397.0	29,432,688.0	13,809,512.0	1,090,495,573.0
Магадалшгүй ажил/2%/	19,163,151.0				
Хүүгийн зардал	65,642,133.0	65,642,133.0			65,642,133.0
ДҮН	1,159,677,681.0	1,140,514,530.0	29,432,688.0	13,809,512.0	1,156,137,706.0